

БАТЛАВ.
ШУТИС-ИЙН МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ
ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ

БАТЛАВ.
..... **ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ**
ЗАХИРАЛ

..... **Н. ЧУЛУУНБАНДИ**

.....

ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ

202.. оны сарын-ний өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Энэхүү санамж бичгийг нэг талаас Монгол улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан 9097554 тоот регистрийн дугаартай, “БЗД 22-р хороо” хаягт байрлах Монгол Улсын Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн бүрэлдэхүүн Мэдээлэл, холбооны технологийн сургууль (цаашид “МХТС” гэх), нөгөө талаас ***** тоот регистрийн дугаартай, ***** хаягт байрлах ***** ХХК (цаашид “компани” гэх ба хамтад нь “талууд” гэх) нар нь хамтран ажиллахаар харилцан тохиролцож талуудын сайн дурын үндсэн дээр эрх тэгш, харилцан ашигтай байх зарчимд тулгуурлан үйлдэв.

Санамж бичгийн зорилго нь: Электроник, техник хангамж болон програм хангамж, технологийн шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэлт, тэдгээрийн үйлдвэрлэлийн технологүүдийг Монгол улсад хөгжүүлэх, чадварлаг боловсон хүчин бэлтгэхэд хамтран ажиллах, оюутнуудад дээрх чиглэлээр практик дадлага эзэмшүүлэх, мөн энэ чиглэлийн судалгаа шинжилгээний ажлыг материаллаг баазаар хангах чиглэлээр харилцан хамтран ажиллана.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Энэхүү санамж бичиг нь талуудын сургалт, эрдэм шинжилгээ, олон нийтийн болон бусад асуудлаар хамтран ажиллах харилцааг зохицуулахад чиглэгдэнэ.
- 1.2. Хамтын ажиллагааны энэхүү санамж бичиг нь талуудын хооронд байгуулах гэрээ, төсөл, хөтөлбөрийн суурь баримт бичиг болно.
- 1.3. Хамтын ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой хувьсах зардлыг талууд тухай бүр нь харилцан тохирч, шийдвэрлэнэ.
- 1.4. Талууд аль нэг талынхаа эрх ашигт харшлах үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- 1.5. Хамтын ажиллагааны санамж бичгийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан эрх зүйн баримт бичиг нь хүчин төгөлдөр даган мөрдөж буй хууль тогтоомжтой нийцсэн байна.

ХОЁР. ХАМТРАН АЖИЛЛАХ ЧИГЛЭЛҮҮД

2.1. Талууд дараах чиглэлээр хамтран ажиллахаар харилцан тохиролцов.

2.2. ***** ХХК талаас:

2.2.1. Электроникийн шинэ бүтээгдэхүүний хөгжүүлэлт, үйлдвэрлэлийн технологийн хөгжлийн чиг хандлага болон практик хэрэглээний талаарх туршлагаасаа хуваалцах, танилцуулах сургалт зохион байгуулах.

- 2.2.2. Судлаач багш, ахисан түвшний төгсөх курсийн оюутнуудад электрон схемийн симуляци бүтээх, хөгжүүлэлт хийх чиглэлээр үйлдвэрлэлийн дадлага хийх боломжоор хангах, дадлагажуулахад туслалцаа үзүүлэх.
- 2.2.3. Техник хангамж, электроникийн технологи хөгжүүлэлтийн чиглэлээр МХТС-ийн ***** мэргэжлийн оюутнуудыг үйлдвэрлэлийн болон танилцах дадлага хийх нөхцөл боломжоор хангах.
- 2.2.4. Дадлага хийсэн оюутнуудыг ажлын байраар хангах болон сурч хөгжихөд туслалцаа үзүүлэх
- 2.2.5. МХТС-ийн сургалтын орчин, судалгааны лаборатори, дадлагын баазыг шинэчлэн сайжруулахад туслалцаа, дэмжлэг үзүүлж санаачлагатай ажиллана.
- 2.2.6. Салбарын зүгээс мэргэжлийн онол практикийн хурал зөвлөгөөн зохион байгуулахад эрдэмтэн багш, оюутнуудыг оролцуулах;
- 2.2.7. Төгсөгчийн зайлшгүй эзэмшсэн байх, орчин үеийн ажлын байранд нэн шаардагдах мэдлэг, ур чадвар, хандлага, төлөвшилтийг тодорхойлох чиглэлээр хамтран ажиллаж, боломжит ажлын байраар хангах;
- 2.2.8. МХТС-ийн оюутны сайн дурын байгууллагууд, клуб, дугуйлангуудын үйл ажиллагааг боломжит хэлбэрүүдээр дэмжиж ажиллана.
- 2.2.9. Бүтээгдэхүүн хөгжүүлэлт, бизнесийн үйл ажиллагаандаа МХТС-ийн оюутан, багш судлаачдыг оролцуулах, инноваци бий болгоход хамтран ажиллана.

2.3. МХТС-ийн талаас:

- 2.3.1. Технологийн судалгаа, хөгжүүлэлтийн хийгдэж буй ажил, түүний үр дүнгийн талаар мэдээлэл харилцан солилцох;
- 2.3.2. Хамтарсан болон захиалгат эрдэм шинжилгээ, судалгаа, боловсруулалтын ажил гүйцэтгэх, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх санаачлага гаргаж талуудын төлөөллийг оруулах, шаардлагатай мэргэжлийн дэмжлэг үзүүлэх;
- 2.3.3. Электроник, мэдээллийн технологийн инноваци хийхэд удирдлага, багш, оюутнуудыг хамтруулан сургалт, хэлэлцүүлэг, эрдэм шинжилгээний хурал, туршлага солилцох, судалгааны ажил хийх, чадваржуулах үйл ажиллагааг хамтран зохион байгуулж нээлттэй хамтарч ажиллах;
- 2.3.4. Электроникийн шийдэл, хөгжүүлэлт хийхэд судлаач-багш нараар онол арга зүйн талаас туслалцаа үзүүлэх, зөвлөмж зөвлөгөө өгөх;
- 2.3.5. Оюутнуудын заах арга зүйн хичээлийн хөтөлбөрөөр электроник, ухаалаг технологийн инновацийн суурь мэдлэг олгох, технологийн хөгжлийн дэвшлийн талаарх мэдээлэл өгөх;
- 2.3.6. Сургалтын хөтөлбөр, төгсөгчдийн ажил эрхлэлтийн талаарх зэрэг хамтын ажиллагааны хүрээнд шаардлагатай мэдээллээр хангах;
- 2.3.7. МХТС нь хамтран ажиллагч байгууллагын техник, технологийн чиглэлийн мэдлэг, ур чадваруудыг тодорхой хичээлийн хөтөлбөрт багтаан оюутанд эзэмшүүлэхэд анхаарч ажиллана;
- 2.3.8. Талууд нь хамтрагч байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээ, техник технологийн шинэчлэл, шийдэлтэй холбоотой асуудлуудыг сургуулийн профессор багш нартай хамтран, мөн оюутнуудад төгсөлтийн, дипломын

ажлын сэдэв санал болгох, удирдагчаар ажиллах замаар шийдвэрлэхэд санаачлагатай ажиллана;

ГУРАВ. ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ

- 3.1. Талууд хууль дээдлэх зарчмаар санамж бичгийг хэрэгжүүлж, шууд харилцана.
- 3.2. Хамтын ажиллагаа нь талуудын эрх ашиг, хөгжлийн алсын хараа, эрхэм зорилгод нийцсэн байна.
- 3.3. Талууд санамж бичгийн хэрэгжилтийн үр дүнг жилд нэг удаа тайлагнан үнэлэлт дүгнэлт өгч, цаашид хэрхэн сайжруулах талаар хэлэлцэн шийдвэрлэнэ.
- 3.3. Хамтын ажиллагаа нь улс төр, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлүүдээс үл хамаарч, урт хугацаанд харилцан туслах, хамтран ажиллах, итгэлцэх зарчимд суурилна.

ДӨРӨВ. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХУГАЦАА

- 4.1. Хамтын ажиллагаа нь байнгын харилцаа холбоо, харилцан тусалж дэмжих, эх орондоо өндөр технологи, инноваци, электроник, үйлдвэрлэлийн технологийг нэвтрүүлэх, хөгжүүлэхэд чиглэсэн учир хугацаагүй байнгын хамтран ажиллах зарчимд тулгуурлана.
- 4.2. Хамтын ажиллагааны санамж бичгийн үр дүнгийн талаар хамтрагч талууд харилцан хэлэлцэн цаашид хэрхэх шийдвэрийг хамтран гаргаж санал бодлоо солилцож дэмжиж ажиллана.
- 4.3. Талуудын аль нэгэн энэхүү санамж бичгийг цуцлах талаар албан бичгээр мэдэгдвэл, мэдэгдэл өгснөөс хойш ажлын 10 хоногийн дараа хүчингүй болно.
- 4.4. Энэхүү санамж бичигт талуудын бичгээр үйлдсэн зөвшилцлийн үндсэн дээр өөрчлөлт оруулж болно.

ТАВ. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

- 5.1. Санамж бичгийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан аливаа маргааныг хууль, эрх зүйн хүрээнд харилцан ойлголцох, хүндэтгэх зарчимд тулгуурлан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

ЗУРГАА. ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

- 6.1. Санамж бичиг нь талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд талуудын харилцан тохиролцсоноор нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 6.2. Энэхүү санамж бичгийг хоёр хувь бичгээр үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгална.